



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/274

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Засгийн газрын "Журам шинэчлэн батлах тухай" 2020 оны 206 дугаар тогтоолын 3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинэжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинэжилгээ, үнэлгээ хийж үр дүнг үнэлэх ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд: О.Отгонтуяа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
Б.Орбиш (Архив, бичиг хэргийн эрхлэгч)
Г.Хулан (Нийгмийн ажилтан)

2.Хяналт-шинэжилгээ, үнэлгээний тайланг удирдамжид заасан заалт нэг бүрийг нарийвчлан гаргаж, үнэлэлт дүгнэлт өгч нэгтгэж ажиллахыг хэсгийн дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

